

“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ” ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

2023 он

## ТАЙЛАН

Монгол Улсын Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх буюу тус хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7-д “Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэсэн суурь зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.6-д “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.”, 4.6.6-д “Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, зэвсэгт хүчний олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд болон Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 35-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”-аар тусгасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөл, холбогдох материалыг боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг удирдлага болгон Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан ба улсын төсвөөс гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д үндэслэсэн.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцох судалгааны зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах зэрэг юм.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6.1.2-т “энэ хуулийн 7.1.3-т заасан зардлыг жил бүрийн төсөвт тусгах асуудлыг шийдвэрлэх”-ийг Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд, 7.1.3-т “энхийг дэмжих ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгуулах асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхэд тус тус тусгасан.

Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд зардал гарахгүй бөгөөд энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бэлтгэл ажилд шаардлагатай зардлыг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал нь сургалт бэлтгэл, хангалт, сонгон шалгаруулалт, оролцох үеийн зардлаас бүрдэх бөгөөд уг зардлыг жил бүрийн улсын төсвийн Батлан хамгаалах болон Хууль зүй, дотоод хэргийн арга хэмжээний зардалд тусгасан байна”, 15.2-т “Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүний цалин хөлс, хангамж, эдийн засгийн бусад баталгааг төр хариуцна.” гэж тусгах нь Зэвсэгт хүчний тухай хуулийн 18<sup>1</sup> дүгээр зүйлийн 18<sup>1.1</sup> дэх хэсэгт “Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүнийг сургах, чадавхыг нэмэгдүүлэх, батлан хамгаалах салбарын алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилго бүхий Зэвсэгт хүчний хөгжлийн сантай байна.” гэж, 18<sup>1.3</sup> дахь хэсэгт “Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна: 18<sup>1.3.1</sup>.зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг сайжруулах;”, 18<sup>1.3.4</sup>.энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбоотой бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх;” гэж тус тус заасантай нийцэж байгаа тул улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй болно.

---oO---